



АГВАН-ИШТҮВДЭНГИЙН “ДАРА ЭХИЙН ҮНДЭСНИЙ ГАРСАН УГИЙГ ТОДОРХОЙ ҮЙЛДЭГЧ ТҮҮХ АЛТАН ЭРИХ” ЗОХИОЛЫН ТУХАЙ

Д.Сумъяа

Хэл зохиолын хүрээлэн

Цахим шуудан: hasaa_11@yahoo.com

Агуулга

Энэ өгүүлэлд XIX зууны үеийн Их хүрээний равжамба Агван-Иштүвдэнгийн төвд хэлээр зохиосон Дара эх бурханы тухай бүтээлийн тоймыг өгүүлэв. Үүнээсээ үндэслэн түүний Дара эх бурханы уг гарлын /origin/ тухай зохиолыг нь танилцуулав. Энэ Дара эх бурханы уг гаралын тухай зохиол нь Бурханы шашины ард түмний бичгийн зохиолд дэлгэрсэн байна. Монголын шашины зүтгэлтэн эрдэмтэй лам нар Энэтхэг төвдөөс уламжлалтай зарим зохиолыг бүтээхдээ багшийнхаа заасан уламжлалыг дагадаг уламжлалтай. Тэр уламжлал энэ зохиолд тод харагдаж байна.

Түлхүүр үг: Агван-Иштүвдэн, Дара эх, алтан эрих,

Даранатын зохиол “Дара эхийн үндэсний угийг тодруулагч домог алтан эрих нэрт оршвай” (Т.: sgröl ma'i rgyud kyī byung khung gsal par byed pa'i lo rgyus gser gyi phreng ba zhes bya ba bzhugs so//) зохиол нь монголчуудын дунд бар хэвлэл болон гар бичмэлээр хуулагдан өргөн дэлгэрсэн байна.

Түүний нэг нь равжамба Агван-Иштүвдэнгийн (Т.: sgröl ma'i rgyud kyī byung khungs gsal par byed pa'i lo rgyus gser gyi phreng ba) “Дара эхийн үндэсний гарсан угийг тодорхой үйлдэгч түүх алтан эрих” бар хэвлэл болоод (Т.: sgröl ma'i rgyud kyī 'byung khungs gsal par byed pa'i lo rgyus gser gyi phreng ba zhes bya ba bzhugs so) хэмээх гар бичмэл Дара эхийн уг гарвалын түүх “Алтан эрих” бүтээл байна. Равжамба Агван-Иштүвдэнгийн гар бичмэл ийм жүнхэнг төвд судлаач П.Ням-Очир 2011 оны 11-р сард Хөвсгөл аймгийн Жаргал сумын харьяат О.Бадамдорж хэмээх өндөр настнаас олж авчирсан байна. Энэ хүн Далай Чойнхор вангийн хошууны Жамбалдорж номун хааны өвийг хадгалагч бөгөөд түүний номын санд хадгалагдаж иржээ.

Агван-Иштүвдэнгийн энэ гар бичмэл судар нь 35 x 8,5 см хэмжээтэй орос шаргал цаасан дээр улаан өнгөөр давхар хүрээ татсан. Дотор улаан хүрээ нь 29 x 7,2 см хэмжээтэй. Нэг нүүртээ 7 мөрөөр төмөр үзгээр хар бэхээр бичсэн. 22 хуудас. Эхлэл төгсгөл бүрэн. Гаргацтай. Энэ судар нь Даранатын “Дара эхийн үндэсний угийг тодруулагч домог алтан эрих нэрт оршвай” зохиолыг хуулан бичээд түүний араас төгсгөлийн үг нэмж бичжээ.

Даранатын зохиолын төгсгөлийн үг нь Т.: Ma rgyud rgyal po zab mo'i mthar thug pa/ sGrol ma 'byung ba'i rgyud kyī byung khungs rnams/ bla ma'i gsung bzhing bkod 'di rgyal khams pa/ Ta ra na tha zhes byas sbyar ba yin// ces pa rang lo sum cu pa la chos gra gser mdog can du smras pa'o// dge legs 'phel// [sgröl ma'i rgyud kyī byung khungs gsal bar byed pa'i lo rgyus gser gyi phreng ba zhes bya ba bzhugs so// 63-р нүүрт] Эхийн үндэсний хаан гүн нарийн эцэст хүрсэн Дара эх гарсаны дандарын гарах уг нугуудыг багшийн айлдсанчлан зохиосон энэ жалхамба Даранат нэрт найруулсан болой хэмээн өөрийн гучин насан дор номын хүрээ Алтан өнгөт хэмээх хийд дор



өгүүлбэй гэсэн байдаг.

Энэхүү Даранатын төгсгөлийн үгийн араас равжамба Агван-Иштүвдэн өөрийнхөө төгсгөлийн үгийг залгуулан нэмж бичсэн байна. Үүнд: Om sa shi// gang gi mtsan tzam yid la dran pas kyang// 'jigs chen sdug bsngal 'bar ba'i me lce'i tsogs// thugs rje'i char chen 'bab pas zhi mdzad ma// rgyal ba kun yum sgrol ma'i zhabs la 'dud// 'phags ma gang gi rmad byud ngo mtsar gtam// kun mkhyen ta ra na tha'i gsung rgyun 'di// khu re chen mo tzo ka'i khams tsan gyi// dge slong ngag dbang chos 'dzin zhes bya bas// par du bsgrun pa'i rnam dkar dge ba'i mthus// bdag dang mkha'

“Ом суважди

Алины алдар төдийг сэтгэл дор дурьдсанаар ч

Их аюул зовлон бадарсан галын дөлийн чуулганыг

Нигүүлсэнгүйн их хурыг буулгаснаар амирлуулан зохиогч

Ялгуугсан бүгдийн эх Дара эхийн өлмийд сөгдмү.

Хутагтай эх алины тансаг гайхамшигтай тууж

Хамгийг айлдагч Даранатын номлолын үргэлжлэл үүнийг

Их хүрээний Зога аймгийн

Гэлэн Агванчойнжин хэмээгч бээр

Хэвлэн гаргасны нэн цагаан буяны хүчээр

Би ба огторгуй сацуу амьтан хоцролгүй

Төрөл бүхэнд гэтэлгэгч Дара эх бээр

Хагацалгүй даган барихын уг дор болох болтугай

Хэмээх үүнийг Их хүрээний Зога аймгийн

Сүжиг хичээл оюун лугаа төгөлдөр

Гэлэн Агванчойнжин бээр Дара эхийн номын гаралын хэвийг бүтээх цагт

энэ мэт нэг хэрэгтэй ёсыг өгүүлсэн мэт

Тойны дүрст равжамба Хэлний эрхэт бээр бичсэн үүгээр

гэтэлгэгч хутагтай Дара эх бээр эгнэгт даган барих ямагтын шалтгаан болох болтугай. Сарва за га да” - гэжээ.

Энэ нь Дара эх таны алдрыг сэтгэлдээ дурдахын төдий л нигүүлсэхүйн хураар их түймэр мэт аюул зовлонг түргэнээ амирлуулах Дара эхэд сөгдмү гэж залбирал тавиад Дара эх таны гайхамшигт тууж Даранатын зохиолыг Их хүрээний Агванчойнжин хэвлэн гаргасны энэ буянаар би болоод бүх амьтад төрөл бүхэндээ Дара эхэд хагацалгүй даган барих болтугай хэмээх ерөөлийг тавиад ийм учир ерөөлөөр равжамба Агван бээр бичсэн гэж Дара эхийн энэ гайхамшигтай туужийг бичих

mnyam 'gro ba ma lus pa// skye ba kun du rje btzun sgrol ma yis// 'bral med rjes su 'dzin pa'i rgyur gyur cig// ces pa 'di yang khu re chen mo tzo ka'i khams tsan gyi dad brtson blo gros dang ldan pa dge slong ngag dbang chos 'dzin nas sgrol ma chos 'byung gi bar bsgrubs pa'i tse 'di lha bu zhig dgos tsul mol ba lhar// btzun gzugs rab 'byams pa ngag gi dbang pos bris pa 'dis kyang rje btzun ma 'phags ma sgrol mas rnam pa kun du rjes su 'dzin pa kho na'i rgyur gyur cig// sarba dza ga da// [sgrol ma'i rgyud kyi 'byung khungs gsal par byed pa'i lo rgyus gser gyi phreng ba zhes bya ba bzhugs so// 22a нүүрт]

болсон учир шалтгаанаа бичжээ.

Равжамба Агван-Иштүвдэн нь төвд хэлээр дөрвөн боть зохиолтой бөгөөд Дара эхийн холбогдол бүхүй зохиол нь түүний “Га” буюу гуравдугаар ботид хэвлэгдсэн байна. “Равжамба Агван-Иштүвдэнбалсангийн “Габум”-ын гарчиг оршив” (Т.: rab 'byams pa ngag dbang ye shes thub bstan dpal bzang po'i bka' 'bum gyi dkar chag bzhugs). Энэ гарчиг нь 45 x 8,5 см хэмжээтэй, дотор хүрээ нь 36 x 5,8 см. Нэг нүүртээ 6 мөрөөр бичсэн. 9 хуудас



юм. Үүнд Агван-Иштүвдэнгийн бүтээлийн гарчгийг жагсаасан учир түүний Дара эхийн зохиолын гарчиг мөн энд байна.

Үүнд: (T.sgrol ma'i rgyud kyi byung khungs gsal par byed pa'i lo rgyus gser gyi phreng ba) “Дара эхийн үндэсний гарсан угийг тодорхой үйлдэгч түүх алтан эрх”, (T.: rje btzun sgrol ma la snyan ngag don rgyan so lnga'i sgo nas bstod pa dge mtsan gсар ba'i dga' ston 'dren byed dpyid kyi pho nya'i glu dbyangs) “Гэтэлгэгч Дара эхийг зохист аялгууны утгын гучин таван чимгийн үүднээс магтсан шинэхэн сайн тэмдэг бэлгэт баярын хуримыг удирдагч хаврын элчийн эгшиг дуун”, (T.: rje btzun sgrol ma'i ngo mtsar ba'i che ba dang bstod pa phyag 'tsal nyer gcig ma'i phan yon bcas mdo tzam du brjod pa utpala'i phreng mdzes) “Гэтэлгэгч Дара эхийн гайхамшигт эрдэм хийгээд магтаал хорин нэгэн мөргөлтийн тус эрдэм сэлтийг товчийн төдийд өгүүлсэн удвалын үзэсгэлэнт эрх”, (T.: sgrol bstod phyag 'tsal nyer gcig ma'i ngag 'grel nyung du bstod pa'i tsul du bya ba utpal 'phreng ba) “Дара эхийн магтаал - Хорин нэгэн мөргөлтийн үгийн тайлбар өчүүхэн магтсаны ёсонд үйлдсэн удвалын эрх”, (T.: rje sgrol ma'i gsol 'debs byin flabs myur 'jug) “Дара эхийн магтаалын доторхи хатуу үгийн тайлбар”, (rje btzun sgrol ma'i mandal bzhi pa'i cho ga nor bu dbang gi rgyal po'i do shal) “Гэтэлгэгч Дара эхийн дөрвөн мандалын зан үйл чандмань эрдэнийн эрхт хааны унжлага”, (T.: rje btzun ma 'phongs sel sgrol ma la brten nas rang gzhan gyi dbul 'phongs sel ba'i man ngag gter bum sgrub tsul) “Гэтэлгэгч үгүйрлийг арилгагч Дара эхэд шүтэж өвөр бусдын үгүйрлийг арилгагч увдис сангийн хумхын бүтээлийн ёсон”, (T.: 'phags ma sgrol ma'i sgrub thabs tse sgrub) [rab 'byams pa ngag dbang ye shes thub bstan dpal bzang po'i bka' 'bum gyi dkar chag bzhugs. 6a-6v нүүрт] “Хутагт Дара эхийн бүтээлийн арга насны бүтээл” зэрэг Дара эхийн тухай зохиол бүтээлийг жагсаажээ.

Ингэхдээ зохиол бүтээлийн нэрийг зөвхөн дурдан жагсаасангүй. Зарим

бүтээлийн тухайд мөн тэр дор нь тэрхүү гарчигийн ард нь товч тайлбарыг хийсэн байна. Тухайлбал (T.sgrol ma'i rgyud kyi byung khungs gsal par byed pa'i lo rgyus gser gyi phreng ba la rang// 'di ni ta ra na tha'i gsung 'bum gyi gras su bzhugs// [rab 'byams pa ngag dbang ye shes thub bstan dpal bzang po'i bka' 'bum gyi dkar chag bzhugs. 6a нүүрт] гэж “Дара эхийн үндэсний гарсан угийг тодорхой үйлдэгч түүх алтан эрх” энэ нь Даранатын сүмбүмийн аймагт буй. rje btzun sgrol ma'i sgrub thabs la ra// 'di dkon mchog 'jigs med dbang pos mdzad pas gsung 'bum gyi gras su bzhugs// [rab 'byams pa ngag dbang ye shes thub bstan dpal bzang po'i bka' 'bum gyi dkar chag bzhugs. 6v нүүрт] гэж “Хутагт Дара эхийн бүтээх арга” энэ нь Гончигжигмэдваббогийн зохиолын сүмбүмийн аймагт буй гэх буюу sgrol ma phyag 'tsal nyer gcig gi tikka rin po che'i phreng ba dang sgrol ljang sgrub thabs la// 'di ni dge 'dun grub pas mdzad pa'i gsung 'bum gyi gras su bzhugs// [rab 'byams pa ngag dbang ye shes thub bstan dpal bzang po'i bka' 'bum gyi dkar chag bzhugs. 6v нүүрт] гэж “Гэтэлгэгч хорин нэгэн мөргөлтийн тайлбар үнэт эрх ба Ногоон Дара эхийн бүтээх арга” энэ нь Гэндэндүвийн зохиолын сүмбүмийн аймагт буй гэж товч тайлбар хийсэн байна.

Үүнээс үзэхэд Агван-Иштүвдэн нь Энэтхэг төвдийн мэргэдийн эш үндэс номоос суралцаад зарим бүтээлийг өөрөө найруулан бүтээсэн байна. Харин зарим номыг эш үндэст багшийн бүтээлийг шүтэн даган барьжээ. Ийн олон зохиолыг үзэж найруулаагүй, дан нэг зохиолыг үг үсэгчлэн дагаж хувилсан учраа ийн тайлбарлаж өгүүлсэн хэрэг. Иймд Агван-Иштүвдэнгийн энэхүү Дара эхийн уг гарал хувьд Даранатын нэгэнт бүтээн туурвисан тэрхүү бүтээлийг даган баясан барьсан байна. Иймээс Даранатын төгсгөлийн үгийн араас залбирал даатгал номыг даган баяссаны ач тусыг өгүүлсэн өөрийн төгсгөлийн үгийг нэмж бичсэн байна. Монголын шашны зүтгэлтэн эрдэмтэй лам нар Энэтхэг төвдөөс уламжлалтай зарим



зохиолыг багшийн хөтөлсөн иш шүнг барьдаг уламжлалтай. Энэ уламжлал энэ зохиолд харагдаж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. rab 'byams pa ngag dbang ye shes thub bstan dpal bzang po'i bka' 'bum gyi dkar chag bzhugs// Гар бичмэл судар.
2. sgrol ma'i rgyud kyi 'byung khungs gsal par byed pa'i lo rgyus gser gyi phreng ba zhes bya ba bzhugs so// Бар. 9 хуудас
3. sgrol ma'i rgyud kyi byung khungs gsal bar byed pa'i lo rgyus gser gyi phreng ba zhes bya ba bzhugs so. Tibetan cultural printing press. Dharmasala-176215 (Н.Р)
4. Ш.Чоймаа, Л.Тэрбиш, Д.Бүрнээ, Л.Чулуунбаатар. “Буддын шашин, соёлын тайлбар толь”. I. II дэвтэр. 2000 он
5. Д.Бүрнээ, Д.Энхтөр “Төвд монгол толь”. 2001 он
6. Д.Бүрнээ, Д.Энхтөр. “Төвд Монгол илт өгүүлэх нэрийн толь” 2003 он
7. Сумьяа Д. “Дара эхийн магтаалын нээх утга” 2002 он.



Abstract

THE ORIGIN OF TARA WRITTEN BY AGVAN-ISHTUVDEN

This narrative paper is about Tara in Tibetan language and is written by Agvan-Ishtuvden who lived in the city in nineteenth century. Furthermore, story of the origin of Tara is introduced by Agvan-Ishtuvden. The story of the origin of Tara is well spread among in the writings of Buddhist civilians.

When Mongolian researchers and monks are transcribing a Buddhist stories from Tibetan to Mongolian, they pursue traditional stories told by their teachers. Resemblens of the traditions are recognized in this paper.